

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Автотээврийн хэрэгслийн албан журмын даатгалын тогтолцоог анх 1930 онд Замын хөдөлгөөний тухай хуулиар Их Британи улсад нэвтрүүлж эхэлсэн бөгөөд тухайн хуулиар тээврийн хэрэгсэл эзэмшигчид болон жолооч нар нь зам тээврийн хөдөлгөөнд оролцох үедээ гуравдагч этгээдэд учруулж болзошгүй гэм хор, амь насны эрсдэлээс хариуцлагаа даатгуулах ёстой байв. Улмаар Герман улс 1939 онд ижил төстэй хууль тогтоомж болох "Автомашин эзэмшигчдийн албан журмын даатгалыг хэрэгжүүлэх тухай хууль"-ийг баталсан.

Харин Монгол Улсад Жолоочийн даатгалын тухай хууль нь 2011 онд батлагдан 2012 оноос мөрдөгдөж эхэлсэн бөгөөд уг хуулийн дагуу жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг Монгол Улсад хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бий болсон.

Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагааг улс орон даяар хэрэгжүүлж, автотээврийн хэрэгслийн өмчлөгч, жолооч нарыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх ердийн даатгагч нар (15 компани) болон даатгалын мэргэжлийн оролцогчид болох даатгалын зуучлагч, төлөөлөгчөөр дамжуулан уг даатгалд хамруулж байгаа бөгөөд Албан журмын даатгагчдын холбоо нь жолоочийн даатгалын сан (даатгагчдын төвлөрүүлэх хөрөнгө, автотээврийн хэрэгслийн албан татварын 10% (2020 оны Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсон) болон үйл ажиллагааны орлогоос бүрдэх), шуурхай алба болон мэдээллийн нэгдсэн санг эрхлэн явуулж, мөн зам тээврийн ослын хохирогчид хуульд заасан нөхцөл, тохиолдол бүрдэхэд жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгож, хохирогчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажиллаж байна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал нь 2023 оны эцсийн байдлаар ердийн даатгалын зах зээл дэх нийт даатгалын хураамжийн 12.1 хувь, нөхөн төлбөрийн 30.0 хувь, байгуулсан даатгалын гэрээний 52.6 хувийг эзэлдэг бөгөөд нийт байгуулагдсан гэрээний 49.6 хувь нь даатгалын төлөөлөгчдөөр дамжин улс орон даяар борлуулагддаг. Тус даатгал нь тээврийн хэрэгслийн, сайн дурын жолоочийн хариуцлагын даатгал, аяллын даатгал гэх мэт бусад төрлийн арилжааны даатгалуудтай хохирол, нөхөн төлбөр, харилцагчийн судалгаа, даатгалын залилангийн судалгаа гэх мэт дата мэдээллийн хувьд нягт холбогддог, олон улсын ердийн даатгалын зах зээлийн хураамж бүрдүүлэлтэд томоохон байр суурь эзэлдэг бөгөөд даатгалын хураамжийн хэмжээг даатгалын хяналт, зохицуулалтын байгууллагын оролцоотойгоор тогтоодгоос гадна даатгалтай холбогдох маргаан шийдвэрлэлт, даатгалын гэрээ байгуулах, нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь нарийвчилсан зохицуулалт шаарддаг онцлог бүхий арилжааны даатгалын салшгүй нэгэн хэсэг юм.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хэрэгжиж эхэлснээс хойших 10 гаруй жилийн хугацаанд даатгагч, даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч болон даатгалын хохирол үнэлэгч компаниудад зөвхөн тус даатгалаар мэргэшин ажиллаж буй хэдэн зуун мэргэжилтэн, боловсон хүчин буй болж, салбар төлөөлөгчдийн газар байгуулан, техник программ хангамжийг мөн тус даатгалын чиглэлээр хөгжүүлж ирсэн билээ.

Үүнээс үзэхэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал нь даатгалын салбарын хөгжилд чухал нөлөө үзүүлдэг даатгалын бүтээгдэхүүн болон хөгжиж, зам тээврийн ослоос үүссэн санхүүгийн хохирлыг нөхөн төлж, иргэд, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах хэрэгсэл болсон байна.

Гэвч Санхүүгийн зохицуулах хороонд даатгалын асуудлаар ирүүлж байгаа өргөдлийн дунджаар 26.4 (2016 онд 43.9%, 2017 онд 30.5%, 2018 онд 16.3%, 2019 онд 23.0%, 2020 онд 25.0%, 2021 онд 11.4%, 2022 оны 11.5%, 2023 онд 37.5% хувийг тус тус эзэлсэн) хувь нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай холбогддог. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай холбоотой гомдлуудыг авч үзэхэд даатгагч нөхөн төлбөр олгохоос үндэслэлгүйгээр татгалзсан, даатгалын хохирлын үнэлгээ байх ёстой хэмжээнээс бага тогтоогдсон, шуурхай албаны үйл ажиллагаа, даатгалын үнэлгээний зөрүү, хураамж болон АЖДХ-ны үйл ажиллагаатай холбоотой гомдлууд дийлэнх хувийг эзэлж байна.

Энэ нь хуулийг боловсронгуй болгох, гадаад улс орнуудын албан журмын даатгалыг судалж, холбогдох сайн туршлагыг авч хэрэглэх, мөн хуулийн хамрах хүрээ, зохицуулалтуудыг боловсронгуй болгох, албан журмын даатгалын үйл ажиллагаанд техник технологи ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг зайлшгүй шаардлагууд үүсэж байгааг илтгэж байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 8 бүлэг, 26 зүйлтэй бөгөөд даатгалын үйлчилгээг сайжруулах, жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлэх, практикт тулгамдсан асуудлуудыг оновчтой шийдвэрлэх замаар хохирогчийн эрхийг хамгаалахад чиглэсэн дараах шинэчлэл, өөрчлөлтүүдийг тусган боловсруулсан. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хуулийн нэр томьёо, даатгалын зарчим, жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулах этгээд, даатгалд үл хамрагдах нөхцөл зэргийг тусгалаа.

Одоогийн мөрдөгдөж буй хуулийн зорилт хэсэгт зөвхөн зориулалтын зам дээр үүссэн ослын улмаас хохирогчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг шинэчилж зам, тээврийн ослын болон авто зогсоол дээрх хөдөлгөөний улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, даатгуулагч болон хохирогчийн эрх ашгийг хамгаалахаар зохицуулж, даатгалын хамгаалалтын хамрах хүрээг өргөжүүлэх хуулийн зорилтыг тодорхойлов.

Хуулийн нэр томьёо хэсгийг хуулийн зорилттой уялдуулан даатгуулагч, даатгагчийн тодорхойлолтыг шинэчилсэн ба даатгалын тохиолдлын хамрах хүрээг нэмэгдүүлэв. Мөн “хохирогчийн эрхийг хамгаалахтай холбоотой нэгдсэн зохион байгуулалтын бүтэц буюу холбоо” гэж жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нар хамтарч энэ хуульд заасны дагуу байгуулсан хуулийн этгээдийг тодорхойлж, даатгалын компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд хохирогчийн эрх ашгийг хамгаалах, улмаар даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгав.

Даатгалын зарчимд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын бүтээгдэхүүний хувьд даатгалын компаниуд зардлаа хамгийн бага түвшинд байлгах шаардлагыг тусгаж олон улсын сайн туршлагын дагуу ашигтай ч бус, алдагдалтай ч бус байх зарчимд нийцүүлэв. Мөн жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй

даатгагч нь жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ байгуулах хүсэлтээс татгалзахгүй байх зарчмыг нэмж тусгав.

Даатгуулах этгээд нь зөвхөн автотээврийн хэрэгслийн өмчлөгч нь байхыг тусгаж тээврийн хэрэгслээ дагасан зохицуулалтыг бий болгов. Ингэснээр автохэрэгслийн жолооны хүрдний ард хэн байхаас үл хамааран зам тээврийн ослын хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирлыг барагдуулах ба даатгуулагч, хохирогчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт сайжрах юм.

Хоёрдугаар бүлэгт даатгалын гэрээ, түүний хугацаа, даатгалын баталгааны зохицуулалтыг тусгалаа.

Олон улсын сайн туршлагын дагуу даатгалын гэрээний дагуу даатгагчийн хүлээх хариуцлага нь даатгуулагчаас даатгалын хураамж төлөгдсөн өдрийн дараах өдрөөс эхэлж, гэрээний хугацааны сүүлийн өдрийн 24:00 цагт дуусгавар болохоор тусгав. Ингэснээр даатгагчийн хүлээх хариуцлага эхлэх хугацааны зөрүүгээс үүдсэн даатгалын залилангийн тохиолдол гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Мөн даатгалын гэрээ, даатгалын баталгааг цахимаар хүргүүлж болох зохицуулалтыг нэмж тусгаж даатгалын үйлчилгээнд технологийн дэвшлийг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэв.

Гуравдугаар бүлэгт даатгалын үнэлгээ, даатгалын хураамжийн зохицуулалтыг тусгалаа.

Даатгалын үнэлгээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уясанаар Монгол улсын эдийн засаг, иргэдийн амжиргааны түвшинд нийцсэн бодит ханш бүхий нөхөн төлбөрийг даатгуулагчаас олгох давуу талыг бий болгох юм.

Хөгжингүй орнуудын сайн туршлагын дагуу даатгалын хураамжийг эдийн засгийн суурь үзүүлэлт, эрсдэлийн түвшинээс хамааруулсан мэргэжлийн байгууллага, актуарчдын тооцсон бодит судалгаа, шинжилгээ, тооцооллын дагуу уян хатан тогтоодог байх зохицуулалтыг бий болгов. Тухайлбал мэргэжлийн байгууллагаас дээр дурдсан актуар тооцоололд үндэслэсэн даатгалын хураамжийн хэмжээг санал болгож, уг үйл ажиллагаанд Хороо хяналт тавин баталгаажуулж даатгалын хураамжийн хэмжээг тогтоох юм.

Дөрөвдүгээр бүлэгт зөвшөөрөл, бүртгэл, хяналттай холбоотой зохицуулалтыг тусгалаа.

Тус бүлэгт шинээр жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, татгалзах, хяналт тавихтай холбоотой харилцааг шинээр зохицуулсан ба Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэв.

Тавдугаар бүлэгт даатгалын тохиолдол, нөхөн төлбөр, жолоочийн хүлээх үүрэг, хохирогчийн эрх, үүрэг, даатгагч, холбооны эрх, үүрэг, даатгалын тохиолдлыг шалгах, хохирлын хэмжээг тодорхойлж, нөхөн төлбөр тооцох, нөхөн төлбөр олгох, нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх үндэслэл зэргийг тусгалаа.

Даатгалын тохиолдолд үл хамаарах нөхцөлд автотээврийн хэрэгсэл хулгайд алдагдсан, дээрэмдүүлсэн үеийн хохирол, цэргийн ажиллагаа, олон нийтийн үймээн самуун, террорист ажиллагааны улмаас үүссэн үйлдэл болон үр дагавараас хамааралтай хохирол, цөмийн материал, цацраг идэвхит бодис тээвэрлэж явцад үүссэн хохирол болон

үр дагавраас хамааралтай хохирол зэрэг нь даатгалын тохиолдолд үл хамаарахаар шинэчлэн зохицуулсан.

Даатгалын тохиолдлын үед автотээврийн хэрэгслийн эзэмшигч, хохирогч, даатгагч болон Холбооны хүлээх үүргийг шинэчилсэн бөгөөд даатгалын тохиолдлыг баталгаажуулахад технологийн дэвшлийг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж, хөдөө орон нутагт гарсан тохиолдлыг баталгаажуулахад шаардагдах зохицуулалтыг сайжруулж, цагдаагийн үүрэг оролцоог багасган иргэд, даатгуулагчдад үүсдэг хүндрэлүүдийг хөнгөвчлөх зохицуулалтыг бий болголоо.

Мөн даатгалын нөхөн төлбөрийг олгох хугацааг 3 дахин багасгаж ажлын 10 хоногийн дотор нөхөн төлбөр олгодог байхаар зохицуулав.

Зургаадугаар бүлэгт хохирогчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаатай холбоотой харилцааг тусгалаа.

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагч нар хохирогчийн эрхийг хамгаалахтай холбоотой нэгдсэн зохион байгуулалтын бүтэц буюу Холбоог Хороонд бүртгүүлсний үндсэн дээр байгуулах үүрэгтэй ба тус холбооноос даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан, даатгалын тохиолдлын буруутай этгээд тодорхойгүй тохиолдолд хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирлын нөхөн төлбөрийг олгохоор тусгав. Ингэснээр даатгагчид хохирогчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой үйл ажиллагааг илүү түргэн шуурхай хэрэгжүүлэх ба нийгмийн хариуцлага сайжирч даатгалын салбарын нэр хүнд өснө гэж үзсэн.

Долоодугаар бүлэгт жолоочийн даатгалын мэдээллийн сангийн зохицуулалтыг тусгалаа.

Жолоочийн даатгалын мэдээллийн сан дахь аливаа мэдээлэл нь төрийн өмч байхаар тусгасан ба ингэснээр мэдээллийн сангийн программ хангамж, дата баазаас хамааралтай мэдээлэл алдагдах, мэдээллийн аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Наймдугаар бүлэгт жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай холбоотой гомдол маргааныг шийдвэрлэх, хариуцлагатай холбоотой харилцааг тусгалаа.

Тус бүлэгт аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчлэл оруулаагүй болно.